

## ХҮРД ХУВЬЦААТ КОМПАНИЙН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ ТУЗ-ИЙН ДҮГНЭЛТ

Компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд хүрэлцэн ирсэнд талархаж, хурлын ажиллагаанд идэвхтэй, ажил хэрэгч оролцохыг хүсч байна.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг өдөр тутмын 2 тогтмол хэвлэл /Өдрийн сонин, Зууны мэдээ/, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг Улаанбаатар телевиз, Монголын үндэсний олон нийтийн радиогоор 2 удаа зарлаж, Хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэдээллээ.

Компанийн 2023 оны санхүүгийн тайланг мөн өдөр тутмын хэвлэлд нийтэлж, Хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүллээ.

Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайланг Хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд хүргүүлсэн.

Тайлант хугацаанд хувьцаа эзэмшигчдийн тоо болон хувь хэмжээнд өөрчлөлт гараагүй, 2024 оны 03-р сарын 21-ний байдлаар компанийн 135266 ширхэг хувьцааг 2023 онд 99 хүн эзэмшдэг байсан, одоо 100 хүн эзэмшиж байна.

Тайлант хугацаанд компанийн ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталсан бизнес төлөвлөгөө, удирдлагын зардал, компанийн үйл ажиллагаа, ажиллагсдын цалин хөлс урамшуулал, хөрөнгийн өсөлт бууралт, ногдол ашиг, удирдлагын урамшуулал олгох асуудалд анхаарал хандуулан ажиллаж ирлээ.

Компанийн ТУЗ 3 удаа хуралдаж, хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах, ногдол ашиг болон удирдлагын урамшуулал олгох, компанийн хэтийн хөгжил, засаглалыг сайжруулахад зориулж шинэ залуу боловсон хүчин бэлтгэх, инженерүүдийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлж зэрэг эзэмшүүлэх, бизнес төлөвлөгөөний биелэлт, компанийн үйл ажиллагааг өргөтгөх, компанийн ирээдүйн төлөвлөлт, одоогийн нөхцөл байдлын талаар хэлэлцүүлж барилга угсралтын ажлын явцтай танилцах шинэчлэх зэрэг асуудлуудыг шийдвэрлэлээ.

2022 онд компанийн нэгж хувьцаанд **953,5** төгрөг, нийт **128,983.32** мянган төгрөгийн ногдол ашиг олгосон бол 2023 онд компанийн нэгж хувьцаанд **2256** төгрөг, нийт **304,348.5** мянган төгрөгийн ногдол ашиг олгохоор шийдвэрлэсэн байна.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаас 2023 оны ажлын үр дүнд **"хангалттай"** гэсэн дүгнэлт өгснийг үндэслэн удирдлагын урамшуулал олгох журмын дагуу удирдлагын урамшилд **36.42 сая** төгрөг олгожээ.

2023 оны компанийн удирдлагын зардлыг **525,0** сая төгрөгөөр баталсан бөгөөд гүйцэтгэл нь **385,67** сая төгрөг болж, **139,33 сая** төгрөгийн хэмнэлттэй ажиллажээ.

2024 онд компанийн чухал хэрэгцээт мэргэжлээр 5 удаагийн сургалтанд давхардсан тоогоор 5 хүн хамрагдаж, шинээр буюу мэргэжлийн зэргээ ахиулсан байна. Үүнд: Мэргэшсэн инженер, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан бэлтгэх, цахилгааны групп зэрэг, цахилгаан гагнуурчдын категорийн сургалт, аттестатчлал, кранчин, дохиочин бэлтгэх, хугацаа сунгуулах зэрэг болно. Эдгээр сургалтанд **22.0** сая төгрөг зарцуулжээ.

Компани санхүүгийн хувьд мөнгөн хөрөнгө, материалын зохих нөөцийг бүрдүүлж, эдийн засгийн хүчин чадал өсөн нэмэгдэж байна.

Компанийн үл хөдлөх хөрөнгө өөрчлөлттэй **10 барилга** байгууламж **840.6** сая төгрөг болж нэмэгджээ. /Нарлаг зочид буудлын барилгыг компанийн хөрөнгөн дээр нэмж бүргэсэн./

Үндсэн хөрөнгө оны эхэнд **1,537.5** сая төгрөг байснаа оны эцэст **1,699.6** сая төгрөг болж өөрчлөгджээ.

Байгууллага хүмүүсээс авах БУА-ын санхүүжилт болон авлага оны эхэнд **1,75** тэрбум төгрөг байсан бол тайлант хугацаанд **7,84** тэрбум төгрөгөөр нэмэгдэж, **7,39** тэрбум төгрөгөөр буурч, оны эцэст авлага **2,17** тэрбум төгрөг болж, авлага **439.8** сая төгрөгөөр өссөн байна.

Мөн байгууллага хүмүүст өгөх өглөг оны эхэнд **3,22 тэрбум** төгрөг байсан бол тайлант хугацаанд **1,2 тэрбум** төгрөгөөр нэмэгдэж, **1,35 тэрбум** төгрөгөөр буурч, оны эцэст **3,07 тэрбум** төгрөг болж өглөг **156,5** сая төгрөгөөр буурсан байна.

БУА-ын урьдчилгаа буюу захиалагчийн хөрөнгө оны эхэнд **3,76 тэрбум** төгрөг байсан бол оны эцэст **1,12 тэрбум** төгрөг болж, **2.64 тэрбум** төгрөгөөр буурсан байна.

Бид өнгөрсөн онд **7 тэрбум 995 сая** төгрөгийн БУА гүйцэтгэж, **1 тэрбум 754 сая** төгрөгийн орон сууцны үйлчилгээний ажил, нийт **9 тэрбум 749 сая** төгрөгийн барилга угсралт, ажил үйлчилгээ эрхэлж **6 тэрбум 719 сая** төгрөгийн зардал гаргаж, барилга угсралтын хувьд **5 тэрбум 46 сая** төгрөгийн ашигтай, **1** төгрөгийн БУА-ыг **69** мөнгөөр гүйцэтгэж, барилга угсралтын хувьд 31 %-ийн ашигтай ажиллажээ. Дотоод аж ахуйн нэгжүүд: төмөр хийц **201.29 сая** төгрөг, бетон эдлэлийн үйлдвэр **119.7 сая** төгрөгний ажил үйлчилгээ, үйлдвэрлэл явуулж, материал хангамж **51 сая** төгрөгний гадагш борлуулалт хийж, түрээсийн орлого **117,45 сая** төгрөг, бусад ажил үйлчилгээнээс **142,1 сая** төгрөгийн орлого оруулсан байна.

Компанийн нийт борлуулалт 2023 онд **9 тэрбум 749 сая** төгрөг бөгөөд татварын өмнөх ашиг **5 тэрбум 627 сая** төгрөг, цэвэр ашиг **5 тэрбум 46 сая** төгрөг байна.

Дээрх нийт ашгийг үйл ажиллагааны чиглэлээр задалж харуулья. Үүнд: Барилга угсралтын ажлын ашиг **3 тэрбум 30** сая төгрөг, түрээсийн ашиг **117,4** сая төгрөг, бусад орлого **142,1** сая төгрөг, банкны хадгаламж, харилцахын хүүгийн ашиг **2,635,51** сая төгрөг, компанийн хэмжээнд ашигт ажиллагааны түвшин **51,7%** байна. Ашгийг задалж үзвэл: Өмнөх онуудад хийж гүйцэтгэсэн БХБ Яамны захиалгатай Сүхбаатар аймгийн Цэвэрлэх байгууламж барих ажлын материалын үнийн өсөлтийн санхүүжилт 1,5 тэрбум төгрөгийн санхүүжилт олгогдсон, мөн компанийн мөнгөн хөрөнгийг Lend.mn, Ондоо ХХК-ийн 20-25% хүүтэй бонд авч, хүүгийн урамшуулал авсан нь голлох нөлөө үзүүлсэн байна. Тус 2 бондын хугацаа дуусаж, эргэн төлөлт 100% хийгдсэн болно.

Энэ онд улсын төсөвт төлөх НӨАТ, аж ахуйн нэгжийн ашгийн татвар, хүн амын орлогын татвар, үл хөдлөх хөрөнгийн, газрын, тээврийн хэрэгслийн татварт **879,5** сая төгрөг, мөн нийгмийн даатгалын шимтгэлд **286.4 сая** төгрөг төлж, улсын татварын өмнө хүлээсэн үүргээ бүрэн биелүүлсэн байна.

2023 онд бизнес төлөвлөгөөгөөр компани нийт **5,1 тэрбум** төгрөгийн ажил үйлчилгээ гүйцэтгэх ба үүнээс **4,42 тэрбум** төгрөгийн барилга угсралтын ажил гүйцэтгэж, **353,8 сая** төгрөгийн ашигтай байхаар төлөвлөсөн ч нийт борлуулалт **9 тэрбум 749 сая** төгрөг бөгөөд цэвэр ашиг **5 тэрбум 046 сая** төгрөг байна нь төлөвлөгөөг биелүүлж ажилласныг харуулж байна.

Компани 2023 онд

- Увс аймгийн Улаангом, Цагаанхайрхан, Зүүнговь, Завхан, Баруунтуруун, Өмнөговь сумын 6-0,4кВ цахилгаан түгээх сүлжээг шинэчлэх, сайжруулах ажлын **5 тэрбум 212 сая** төгрөгийн;

-Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын Шинэ суурьшлын бүс байгуулах Түлхүүр гардуулах нөхцөлтэй ажлын **3 тэрбум 595 сая** төгрөгийн цахим тендерт оролцож, нийт **8,8 тэрбум** төгрөгийн 2 тендерт шалгарсан байна.

Бид өнгөрсөн онд шинээр эхэлсэн болон урьд оны шилжсэн барилгуудад **7 тэрбум 944 сая** төгрөгийн угсралтын ажил гүйцэтгэсэн, Үүнээс томоохныг дурдвал:

1. Сүхбаатар аймгийн төвийн цэвэрлэх байгууламж болон бусад туслах үйлчилгээний барилга угсралтын ажил **4 тэрбум 315 сая төгрөг**
2. Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын Эко хорооллын гадна инженерийн шугам сүлжээний барилга угсралтын ажил **-1 тэрбум 327 сая төгрөг /2023 онд гүйцэтгэсэн/**
3. Сүхбаатар аймгийн шинэ суурьшлын бүсийн гадна инженерийн шугам сүлжээний ажил **674,6 сая төгрөг /2014-2015 онд гүйцэтгэсэн ажлын санхүүжилт 2023 онд орж ирсэн/**
4. Увс Хөв цөөрөм угсрах ажил **792,4 сая төгрөг /2020-2021 онд гүйцэтгэсэн/**  
Баянзүрх дүүрэгт баригдсан 84 айлын 15 давхар орон сууцыг 2020 оны 12-р сарын 10-нд улсын комисст хүлээлгэн өгч, ашиглалтанд оруулсан бөгөөд 2023 онд **589,9 сая** төгрөгийн орон сууц борлууллаа.

Тайлант хугацаанд жилийн дунджаар **80-90** хүн ажиллаж, **1 тэрбум 174.1 сая** төгрөгийн цалин олгож, компанийн ажилтны сарын дундаж цалин **1 сая 223 мянган** төгрөг болж, өмнөх **/1 сая 107.0 мян.төгрөг/** оныхоос **10 %** буюу **116 мянган** төгрөгөөр өсчээ.

Компанийн мөнгөн хөрөнгийн ашиглалтыг сайжруулахад анхаарч, харилцагч банкуудаас харилцахын үлдэгдэлд олгох хүүгийн хувь хэмжээний талаар санал авч, судалгаа хийсний үндсэн дээр хадгаламжид өндөр хүү олгож байгаа Төрийн банк, ХААН банканд мөнгөн хөрөнгийн ихэнх хэсгийг байршуулж, хугацаатай хадгаламжийн хүү авч байна. 2023 онд байгууллагын хугацаатай хадгаламжийн хүүд нийт **2 тэрбум 635.34 сая** төгрөгийн хүүгийн орлого авсан байна.

2023 онд мөнгөн хөрөнгийн ашиглалт, банкны хүүг нэмэгдүүлэх болон авлага, өглөгийг барагдуулах буюу эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэхэд амжилттай ажилласан байна.

Компанийн “Барилгачин” сувиллыг 2023 онд цэцэрлэгийн зориулалтаар түрээсэлсэн байгаа. Баянзүрх орон сууцны 1-р давхрын цэцэрлэгийн зориулалтаар барьсан хэсгийг бас түрээсэлж үйл ажиллагаа явуулж байгаа.

Энэ онд спорт залны үйл ажиллагаа тогтворжиж 2023 онд **148,7 сая** төгрөгийн орлого оруулсан байна.

Компанийн ашиглалтгүй буюу илүүдэлтэй ажлын байруудыг түрээсээр ажиллуулж, 2023 онд **117,45** сая төгрөгийн түрээсийн орлого оруулсан байна.

2023 онд Сүхбаатар аймгийн төвийн цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажлыг гүйцэтгэж, улсын комисст хүлээлгэн өгсөн.

Компанийн улирал, жилийн тайлан балансыг хугацаанд нь гаргаж, Аудитын байгууллагаар хяналт хийлгэж, Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороо, Дүүргийн татвар, санхүүгийн хэлтэст тушааж ажиллаж байна.

Компанийн үйл ажиллагаа, эдийн засгийн үзүүлэлт, 2023 оны бизнес төлөвлөгөөний биелэлт, ТУЗ-ийн үйл ажиллагаа тогтворжсон зэргээс харахад компанийн ТУЗ, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааг хэвийн явагдаж, үүргээ биелүүлж ажилласан гэж үзэж байна.

2024 онд компанийн зорилтот үйл ажиллагааны бизнес төлөвлөгөөний төслийг боловсруулсан. Энэ оны ажлын ерөнхий чиглэл, зорилго дараах байдалтай байна. Үүнд:

2024 онд одоогоор хэрэгжүүлэх нь тодорхой байгаа  
-Увс аймгийн Улаангом, Цагаанхайрхан, Зүүнговь, Завхан, Баруунтуруун, Өмнөговь сумын 6-0,4кВ цахилгаан түгээх сүлжээг шинэчлэх, сайжруулах ажлын **5 тэрбум 212 сая** төгрөгийн;

- Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын Шинэ суурьшлын бүс байгуулах Түлхүүр гардуулах нөхцөлтэй ажлын **2 тэрбум 95 сая** төгрөгийн ажлыг гүйцэтгэж, ашиглалтанд хүлээлгэн өгнө.

2024 онд Бизнес төлөвлөгөөгөөр **8.27** тэрбум төгрөгийн борлуулалт, **600.0** сая төгрөгийн ашигтай байхаар төлөвлөсөн.

Цаашид улс, орон нутгийн хөрөнгөөр санхүүжих барилга угсралтын ажлын тендерт оролцож ажил, үйлчилгээ олж авах шаардлагатай байгаа.

Компанийн удирдлагын зүгээс өөрсдийн үндсэн хөрөнгийн ашиглалтыг сайжруулах, гадаад валют тодорхой түвшинд нөөцлөх, эргэлдүүлэх материалын нөөц бүрдүүлэх, банк санхүүгийн бүтээгдэхүүн ашиглах үүнд: Бонд, хувьцаа, хадгаламж, орон сууц барих, сантехникийн материалын худалдаа эхлүүлэх, зарим нэг үл хөдлөх хөрөнгө, үндсэн хөрөнгө оруулалтын судалгаа хийж эрсдэлээс хамгаалах шаардлага үүсээд байна. Мөн компаний олон жилийн төсөл хөтөлбөрт оролцож байсан арвин их туршлага дээр тулгуурлан гадаад худалдаа эрхлэх боломжтой талаар судлаж байна.

Мөн Үндэсний статистикийн хорооноос гаргасан салбарын дундаж цалин, хүн амын дундаж цалингаас Хүрд ХК-ийн ИТА нарын цалин доогуур байгааг улсын жишигт хүргэн нэмэгдүүлэх зорилт тавьж байна. Энэ талаарх ажлыг эрчимжүүлж, Хүрд ОСК-ын ажилтнуудын дундаж цалинг 2023 оны 04-р улиралд салбарын жишиг цалинд хүргээд байгаа.

Компанийн “Хүрд-Орон сууц” салбар одоогоор 20 хүний бүрэлдэхүүнтэйгээр тогтвортой сайн ажиллаж байна.

Компанийн бетон эдлэлийн болон төмөр хийцийн цехийг бие даасан үйлдвэр ХХ Компани болгохоор төлөвлөсөн ч хэрэгжээгүй Хүрд ХК үндсэн бүтээн байгуулалтын ажилд оролцон ажиллаж байна.

2024 оноос Хүрд Бетон хийц үйлдвэрлэлийн бараа бүтээгдэхүүний нэр төрлийг олшируулж, Бетон Зуурмагын үйлдвэрлэлийг өргөжүүлэх судалгаа хийгдэж байна.

Хүрд ХК-ийн ажилтан, албан хаагчид өвлийн буюу барилга угсралтын ажил зогссон үед цалингүй сул зогсолт хийдэг нь хүний нөөц хийгээд цалингийн асуудалд сөрөг нөлөөтэй байдаг. Өвлийн улиралд ИТА нарыг ажилтай байлгах, 365 хоног үйл ажиллагаа явуулах шаардлагатай тулгардаг.

Иймд вакуум цонх, бүх төрлийн хийц үйлдвэрлэл, худалдааг түлхүү анхаарч, уламжлалт тендерт оролцох ажлыг солонгоруулах, үйл ажиллагааны чиглэлд оролцох оролцоог нь багасгах төлөвлөгөөтэй байна.

Хүрд ХК-ийн удирдлагын баг 2023 онд Ажлын алба, Санхүүгийн алба, Үйлдвэрлэлийн алба, Материал хангамжийн алба, Хүрд орон сууц гэсэн 6 хэсэг нэгж, 80 гаруй албан хаагчийн бүрэлдэхүүнтэй ажиллалаа. Хүрд ХК 2023 онд 5 тэрбум 46 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, нэгж хувьцааны үнэ 45720 төгрөгөөс 98400 төгрөг хүртэл буюу 2,15 дахин өсөлт үзүүлж, нэгж хувьцаанд 2250 төгрөгийн ногдол ашиг олгох шийдвэр гаргаад байна.

Манай компани 2023 онд Азийн хөгжлийн банк, Барилга хот байгуулалтын яамны хамтран хэрэгжүүлсэн Баруун-Урт хотын Цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажлыг дуусган, амжилттай хүлээлгэн өгч, Баруун Урт хотод олон жил шийдэгдээгүй байсан ахуйн бохирыг ил задгай асгаж, аймаг даяар үнэртдэг байсан бохир усыг 98% хүртэл цэвэршүүлэн асгаж, хүн ам, байгаль орчинд ээлтэй ажлыг хийж гүйцэтгэлээ. Төслийн явцад БХБЯ-тай гэрээгээр 5 мэргэжилтэн бэлтгэж, цэвэрлэх байгууламжийн ойр орчимд 1000 ширхэг мод тарих ажлыг гүйцэтгэлээ. Тус ажлыг хийж гүйцэтгэх явцад усан сангийн доторлогоо хийх, усан туршилт хийх, ажлын байрны орчин нөхцөл муу, аймгаас туслан гүйцэтгэгч олдохгүй зэрэг хүндрэлтэй нүүр тулгарч байсан.

Мөн дээрх ажлын төсөвт өртөг нь 2018 оны төсвөөр гүйцэтгэгдэж, компани ихээхэн алдагдал хүлээх эрсдэлтэй байсан ч УИХ-ын 88-р тогтоолоор материалын үнийн зөрүү олгох шийдвэр гарсны дагуу үлдэгдэл ажлын материалд үнийн зөрүү тооцох төсвийн тооцоо хийж, БХТ-ийн магадлалаар оруулж, 2,0 тэрбум төгрөгийн цэвэр алдагдлаас 1,5 тэрбум төгрөгийг батлуулж захиалагчид хүргүүлсэн. Энэхүү ажилд компанийн ерөнхий захирал Б.Энхжаргал, Ажлын албаны дарга Г.Гантуяа, Хөрөнгө оруулалт хариуцсан дарга Э.Ундрах нары хүчин чармайлт ихээхэн байсныг онцлох хэрэгтэй.

Мөн 2006 онд гүйцэтгэсэн 1-р хороолол-Орбитын чиглэлийн цэвэр усны шугамын ажлын нэмэлт ажлын санхүүжилт 300 сая төгрөгийн төсөвт БХТ-өөр магадлад хийлгэн, Улсын аудитын газрын шалгалтаар оруулж, БХБ Яамаар шийдүүлсэн боловч Сангийн Яамнаас тодорхойгүй шалтгаанаар хассан сөрөг муу мэдээтэй байна. 2014 оноос хойш хөөцөлдөж байгаа Сүхбаатар аймгийн Шинэ суурьшлын бүсийн гадна инженерийн шугам сүлжээний ажлын санхүүжилтын ихэнх хэсгийг авч санхүүжсэн боловч 7,5 сая орчим төгрөгийн үлдэгдэл санхүүжээгүй байна.

2023 онд цаг уурын гамшгийн улмаас Хүрд ОСК, Баруун-Урт сумын Цэвэрлэх байгууламжийн барилга байгууламж, Хүрд Өргөө хотхонуудад үерийн эрсдэл үүссэн боловч, чадварлаг хамт олны хүчээр машин, механизм, түрээсийн зардлаа өөр хохиролгүй давж чадлаа.

2024 оны 7 сараас эхлэн Хүрд ХК-ийн өөрийн нөөц бололцоог бүрэн ашиглаж, Хүрд Бетон хийц, Төмөр хийц ХХК-ийн үйл ажиллагааг эхлүүлэн, вакуум цонх, бетон зуурмагийн үйлдвэр байгуулах бэлтгэл ажлыг хангаж эхлээд байна. Мөн компанийн эзэмшлийн барилга байгууламжууд нь 1960 онд ашиглалтанд орсон, сүүлийн 10 гаруй жил урсгал засвар хийгдээгүй зэргээс үйл ажиллагаа явуулах боломжгүй байгааг их засвар хийж халаалт, цэвэр ус, тог цахилгаантай болгох, дээвэр, орц, гарц, цонх зэргийг иж бүрэн засварлаж ажилчдын тав тухыг хангах ихээхэн шаардлагатай байна. Цаашид Хүрд ХК-г үндсэн үйл ажиллагааг авч явах хэдий ч хөрөнгийн зах зээл /хувьцаанаас бусад/ үйлдвэрлэл, худалдаа, түрээсийн салбарт илүүтэй ажиллаж чиглүүлэх бодлоготой ажиллаж байна.

2023 онд үйлдвэрлэлийн үйл ажиллагаа хэвийн түвшинд явагдаж, санхүүгийн тогтвортой байдлаа хадгалж, төлөвлөгөөт зорилтуудаа амжилттай биелүүлснийг харуулж байна.

Компанийн 2023 оны удирдлагын зардлын зарцуулалт, инфляцийн түвшинг харгалзан 2024 оны удирдлагын зардлыг **680 сая** төгрөгөөр төлөвлөж байна.

Ажлын үр дүн, компанийн 2023 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланд хангалттай гэсэн дүгнэлтийг компанийн төлөөлөн удирдах зөвлөл өгч хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж байна.

Мөн 2024 оны бизнес төлөвлөгөө, удирдлагын зардлыг батлуулахаар хуралд хэлэлцүүлж байгаад санал бодлоо илэрхийлж баталж өгөхийг хүсье.

Та бүхэнд эрүүл энх, ажлын амжилт хүсэн ерөөе.

Хүрд ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл